



**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,
Сэлэнгэ аймаг, 43081
Утас/Факс: (976)-7036-3040
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ЭЭЛЖИТ
СОНГУУЛЬД ОРОЛЦОХ
МОНГОЛ АРДЫН НАМД**

2024.08.05 № ГНАГ-2024/13-УТА-НА-01
танай _____-ны № _____-т

**Сонгуулийн мөрийн хөтөлбөр хуульд
заасан шаардлагад нийцсэн талаарх дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.4-т заасан төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд 2024 оны аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох Сэлэнгэ аймгийн Монгол Ардын намын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцооны хамт ирүүлж, хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газар нь 2024 оны аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох нам, эвслийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817-1:2020 Тулгуур зарчим, Төрийн аудит MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, Төрийн аудит MNS 6817-8:2020 Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого,

018020489

УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хууль, холбогдох байгууллагаас авсан тайлан, судалгаа, мэдээллийг тус тус шалгуур болгон авч үзсэн.

Дүгнэлт

Сэлэнгэ аймгийн Монгол Ардын намын аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрийн зорилт арга, хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Сэлэнгэ аймгийн Монгол Ардын намын мөрийн хөтөлбөр (12 хуудас)-ийг хавсаргав.

Хувийг: Сэлэнгэ аймгийн Сонгуулийн хороонд

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА



**СЭЛЭНГЭ АЙМГИЙН ИТХ-ЫН 2024 ОНЫ
СОНГУУЛИЙН МӨРИЙН ХӨТӨЛБӨР**

2024-2028

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН
МОНГОЛ АРДЫН НАМЫН ХОРОО**

**СҮХБААТАР ХОТ
2024 ОН**

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН ИТХ-ЫН 2024 ОНЫ ЭЭЛЖИТ СОНГУУЛЬД
СЭЛЭНГЭ АЙМГИЙН МОНГОЛ АРДЫН НАМЫН ХОРООНООС ДЭВШҮҮЛЖ БУЙ
МӨРИЙН ХӨТӨЛБӨР**

2024.06.24



**СЭЛЭНГЭ САЙХАН НУТГАА
“ХАМТДАА ХӨГЖҮҮЛЬЕ”**

Монгол Улсын хөгжлийн Алсын харааг үндсэн чиглэл болгон Монгол Ардын Намаас УИХ-ын 2024 оны сонгуульд дэвшүүлсэн хөгжлийн зорилтуудыг орон нутагтаа хэрэгжүүлэх, Сэлэнгэ нутгийнхаа хөгжлийг шинэ шатанд гаргах зорилгоор аймаг, орон нутгийнхаа ард иргэд, аж ахуйн нэгж, байгууллага, төрийн бус байгууллагуудаас мөрийн хөтөлбөрт тусгуулахаар ирүүлсэн саналуудыг нягтлан үзэж, нэгтгэн дүгнэж, аймгийнхаа нийгэм, эдийн засгийн хөгжлийн өнөөгийн байдалд тулгуурлан, Сэлэнгэ аймгийн Монгол Ардын Намын Хорооноос 2024-2028 онд Сэлэнгэ нутгийнхаа хөгжил, дэвшил, хүн ардынхаа сайн сайхны төлөө хийж, хэрэгжүүлэх ажлаа хураангуйлан тусгасан мөрийн хөтөлбөрөө сонгогч олондоо өргөн барьж байна.

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. ЭРҮҮЛ МЭНД

Эрүүл иргэн – Амьдралын суурь


- 1.1. Хүн амын дундаж наслалтыг нэмэгдүүлэх ажлын хүрээнд эрүүл мэндийн үзлэг, эрт илрүүлгийг тасралтгүй үргэлжлүүлнэ.
- 1.2. “Элэг бүтэн Монгол”, “Хавдаргүй Монгол”, хүүхдийн “Эрүүл шүд”, “Эрүүл хүүхэд”, хөтөлбөрүүдийг үргэлжлүүлж, хүртээмжийг нэмэгдүүлнэ.
- 1.3. Аймгийн хүн амын дунд зонхилон тохиолдож байгаа өвчлөл, эндэгдлийн шалтгааныг судлан тогтоох, урьдчилан сэргийлэх, оношлох, эмчлэхэд Эрүүл мэндийн салбарын үйлчилгээг чиглүүлнэ.
- 1.4. Иргэдэд үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг шуурхай, чирэгдэлгүй болгож үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулна.
- 1.5. Иргэн бүрийг жил бүр урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо шинжилгээнд заавал хамрагддаг болгож хэвшүүлнэ.
- 1.6. Сургууль, цэцэрлэгийн хүүхдүүдэд эрүүл мэндийн үзлэгийг тогтмол зохион байгуулж, эрт илрүүлэх, эрүүлжүүлэх ажлыг чанаржуулна.
- 1.7. Эм, эмнэлгийн хэрэгслийн нийлүүлэлтийн чанар, аюулгүй байдалд тавих хяналтыг сайжруулна.
- 1.8. Эмч, эмнэлгийн ажилтнуудыг үе шаттайгаар гадаад, дотоодод туршлага судлуулж, давтан сургаж, мэргэшүүлж, мэдлэг, ур чадварыг нь дээшлүүлнэ.

- 1.9. Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал, гамшиг, онцгой байдлын үеийн эрүүл мэндийн байгууллагуудын бэлэн байдал, хариу арга хэмжээ авах чадавхыг бэхжүүлнэ.
- 1.10. Эрүүл мэндийн төвүүдийг халуун, хүйтэн ус, ариун цэврийн байгууламжтай болгоно.
- 1.11. Эрүүл мэндийн байгууллагуудын барилгын засвар, тохижилт, өргөтгөл, үйлчилгээг үе шаттайгаар хэрэгжүүлж, техник хэрэгслээр ханган, иргэдэд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг бүх түвшинд шуурхай хүргэх, ая тухтай орчинд оношлох, эмчлэх боломж бүрдүүлнэ.
- 1.12. Эмч, эмнэлгийн ажилтнуудыг орон сууцаар хангах ажлыг хэрэгжүүлж, урт хугацааны хөнгөлөлттэй зээлээр эзэмшүүлж, өмчлүүлснээр тогтвор суурьшилтай ажиллах, амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ.
- 1.13. Орон нутагт өөрийн хүсэлтээр шилжин ирж ажиллах эмч, эмнэлгийн ажилтнуудад олгох урамшууллын бодлогыг хэрэгжүүлнэ.
- 1.14. Аймгийн эрүүл мэндийн салбарт дутагдалтай, нарийн мэргэжлийн эмчээр амжилттай суралцаж байгаа, сургуулиа төгсөөд орон нутагтаа ирж ажиллах Сэлэнгэ аймгийн харьяат оюутанд орон нутгаас олгох дэмжлэгийг бий болгоно.
- 1.15. Өрх, тосгоны эрүүл мэндийн төвд үзүүлэх эмнэлгийн анхан шатны тусламж, үйлчилгээнд шинэ дэвшилтэт арга технологийг нэвтрүүлэх, хурдавчилсан оношилгоо, өдрийн, сэргээн засах, гэрээр үзүүлэх тусламжийн чанарыг дээшлүүлнэ.

ХОЁРДУГААР БҮЛЭГ. БОЛОВСРОЛ

Боловсролтой иргэн - Хөгжлийн суурь

- 2.1. Өсвөр үеийнхнийг эх оронч үзэлтэй, их түүхээ судалж, уламжлалт өв соёлоо дээдэлсэн, “Зөв хүн” болгон төлөвшүүлэх, бага, дунд боловсролын чанарыг дээшлүүлэхэд боловсролын байгууллагуудын үйл ажиллагааг чиглүүлж, хүүхдийн өөрийнх нь авьяаст тулгуурлан хөгжүүлж, амьдралын зөв дадалд сургана.
- 2.2. Бага, дунд боловсролын сургалтын чанарт жил бүр хөндлөнгийн хяналт хийж, эцэг эхчүүдэд танилцуулж, үнэлүүлдэг болно.
- 2.3. Хүүхэд харах үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлж, 1-2 хүртэлх насны хүүхдийг яслийн үйлчилгээнд хамруулан ээжүүдийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлнэ.
- 2.4. Хүүхэд бүрийг сургуулийн өмнөх боловсролд бүрэн хамруулж, сургуулийн анги, бүлэг дүүргэлтийг норматив хэмжээнд хүргэнэ.
- 2.5. Боловсролын тухай хуульд англи хэлийг үндсэн гадаад хэлээр тодорхойлсны дагуу бүх шатны сургалтын байгууллагад англи хэлийг эзэмших нөхцөл, орчныг бүрдүүлж, англи хэлний багш нарыг мэргэжил дээшлүүлэх сургалтад үе шаттайгаар хамруулна.
- 2.6. Цэцэрлэг, сургуулийн орчныг бүрэн камержуулж, хүүхдийн аюулгүй, таатай суралцах орчныг бүрдүүлнэ.
- 2.7. Ерөнхий боловсролын сургуулиудыг дотуур байр, шаардлага хангасан ундны цэвэр ус, ариун цэврийн өрөө, угаалгын өрөөтэй болгож, галын болон ослын шаардлагыг хангуулж, хүүхдэд ээлтэй, эрүүл, аюулгүй орчныг бүрдүүлнэ.

- 
- 2.8. Багшийн ажлын бодит үнэлэмжийг нэмэгдүүлж, мэргэжлийн нэр хүндийг өсгөхийн зэрэгцээ багш нарыг үе шаттайгаар гадаад, дотоодод туршлага судлуулж, давтан сургаж, мэргэшүүлж, мэдлэг боловсрол, ур чадвар, хариуцлага, харилцаа, хандлагыг нь дээшлүүлнэ.
- 2.9. Багшийг орон сууцаар хангах ажлыг хэрэгжүүлж, урт хугацааны хөнгөлөлттэй зээлээр эзэмшүүлж, өмчлүүлснээр тогтвор суурьшилтай ажиллах амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ.
- 2.10. Орон нутагт дутагдалтай мэргэжлээр өөрийн хүсэлтээр шилжин ирж ажиллах багшид олгох дэмжлэгийг бий болгоно.
- 2.11. Политехникийн коллежийг мэргэжлийн багшаар бүрэн хангаж, суралцах мэргэжлийн төрөл, элсэлтийг нэмэгдүүлж, сургалтын чанарыг дээшлүүлнэ.
- 2.12. Орон нутагт дутагдалтай багшийн мэргэжлээр амжилттай суралцаж байгаа, сургуулиа төгсөөд орон нутагтаа ирж ажиллах Сэлэнгэ аймгийн харьяат оюутанд орон нутгаас олгох дэмжлэгийг бий болгоно.
- 2.13. Тусгай хэрэгцээт хүүхдийг сургууль, цэцэрлэгт сурах, хөгжих боломж, нөхцөлийг бүрдүүлнэ.
- 2.14. Хүүхдийн тоо, эрэлт хэрэгцээнд уялдуулан цэцэрлэг, сургууль шинээр барих, өргөтгөх, барилга байгууламж, дэд бүтэц, сургалтын тоног төхөөрөмжийг үе шаттайгаар сайжруулж, чанартай үйлчилгээ үзүүлэх орчныг бүрдүүлнэ.
- 2.15. Ерөнхий боловсролын сургуулиудын дунд болон хамтын ажиллагаатай улс, хотуудтай багш, сурагч солилцооны хөтөлбөрүүдийг боловсруулан хэрэгжүүлнэ.
- 2.16. Хүүхэд багачуудыг улсын болон олон улсын чанартай уралдаан, тэмцээнд оролцоход дэмжлэг үзүүлдэг, амжилтын үзүүлэлтээр урамшуулал олгодог тогтолцоог бий болгоно.
- 2.17. Хүүхэд хамгаалах, өдөр өнжүүлэх төвийг байгуулж шаардлагатай тохижилт үйлчилгээг улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэх асуудлыг шийдвэрлэнэ.
- 2.18. Зарим сум, тосгоны хүн амын нягтаршил, өсөлт, хүртээмжид үндэслэн гэрт ойр, “Бага сургуулийн цогцолбор” сургуулийг төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээгээр байгуулна.

ГУРАВДУГААР БҮЛЭГ. СОЁЛ, УРЛАГ

Соёлтой иргэн – Ёс суртахууны суурь


- 3.1. “Монгол хүн-Монгол ахуй-Монгол соёл-Монгол урлаг” бодлогыг хэрэгжүүлж, түгээн дэлгэрүүлэхэд соёл, урлагийн байгууллагуудын үйл ажиллагааг чиглүүлнэ.
- 3.2. Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуульд соёлч Монгол иргэнийг сургаж, төлөвшүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
- 3.3. “Соёлч иргэн”, “Соёлч гудамж”, “Соёлч хамт олон” хөтөлбөрийг хэрэгжүүлэн аж ахуйн нэгж, байгууллагууд сар бүр соёлын ажлыг зохион байгуулдаг тогтмол өдөртэй болж, иргэдийн идэвх санаачилга дээр тулгуурлан хот, суурины соёлыг дэлгэрүүлнэ.

- 3.4. "Сэлэнгэ-Хувьсгалын өлгий нутаг" хөтөлбөрийг хэрэгжүүлж, орон нутгийн байгалийн болон түүхэн, дурсгалт газруудыг баримтжуулж, хамгаалан, орчныг тохижуулж, ард түмэнд түгээн дэлгэрүүлж таниулна.
- 3.5. Цахим номын сангийн сан хөмрөгийн үйлчилгээний хэрэглээг нэмэгдүүлнэ.
- 3.6. Музей, соёлын төв, номын сан, орон нутаг судлах танхимыг байнгын ажиллагаатай болгож үзмэр, сан хөмрөгийг баяжуулж, үйлчилгээ, сурталчилгааны чанарыг дээшлүүлнэ.
- 3.7. Соёл урлагийн байгууллагууд ур чадварын өндөр түвшинд урлагийн бүтээл туурвиж, дотоод болон гадаадад аялан тоглолт зохион байгуулж Сэлэнгэ нутаг, Монгол улсаа сурталчилна.
- 3.8. Аймгийн өвөрмөц онцлог, нөөц, технологийн хөгжилтэй уялдсан, бүтээгдэхүүн, үйлчилгээг нэмэгдүүлэх "Соёлын бүтээлч үйлдвэрлэл III" хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
- 3.9. Соёлын биет бус өв, язгуур урлагийн шавь сургалтыг бий болгосон бүлэг, хамт олон, өвлөн уламжлагчдыг дэмжиж, урамшуулах тогтолцоог бий болгоно.
- 3.10. Үндэсний өв соёлоо уламжлан хадгалах, түгээн дэлгэрүүлэх зорилгоор ерөнхий боловсролын сургуулийн сургалтын хөтөлбөрт морин хуурын сургалтыг тусгаж хэрэгжүүлнэ.
- 3.11. Хүүхэд, залуучууд, уран бүтээлчдийг соёл, урлагийн чиглэлээр улсын болон олон улсын чанартай уралдаан тэмцээнд оролцоход дэмжлэг үзүүлдэг, амжилтын үзүүлэлтээр урамшуулал олгодог тогтолцоог бий болгоно.
- 3.12. Соёл, урлагийн ажилтнуудыг орон сууцаар хангах ажлыг төр, хувийн хэвшлийн гэрээгээр хэрэгжүүлж, урт хугацааны хөнгөлөлттэй зээлээр эзэмшүүлж, өмчлүүлснээр тогтвор суурьшилтай ажиллах, амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ.
- 3.13. Соёл урлагийн байгууллагуудыг мэргэжлийн боловсон хүчнээр бүрэн хангаж, ажилтнуудыг үе шаттайгаар гадаад, дотоодод туршлага судлуулж, давтан сургаж, мэдлэг боловсрол, ур чадварыг нь дээшлүүлнэ.
- 3.14. Соёл урлагийн байгууллагуудын барилгын засвар, тохижилт, хөгжим аппаратур, тоног төхөөрөмжөөр хангах ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлж, иргэд ая тухтай орчинд үйлчлүүлэх боломжийг дээшлүүлнэ.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. БИЕЙН ТАМИР, СПОРТ

Эрүүл, чийрэг иргэн – Идэвхтэй амьдрал

- 4.1. Иргэдийг идэвхтэй хөдөлгөөн, нийтийн биеийн тамир спортоор хичээллэх сонирхлыг төрүүлэх, орчныг бүрдүүлэх, сайжруулах, эрүүл чийрэг амьдралыг төлөвшүүлэхэд биеийн тамир, спортын салбарын үйлчилгээг чиглүүлнэ.
- 4.2. Ерөнхий боловсролын сургуулийн биеийн тамирын хичээлийн хөтөлбөрт тусгагдсан цана, тэшүүрээр хичээллүүлэх дугуйлан, секцийн үйл ажиллагааг дэмжиж ажиллана.
- 4.3. Усанд сэлэлтийн спортыг хөгжүүлж, аймаг, бүсийн аварга шалгаруулах тэмцээнийг жил бүр зохион байгуулна.
- 4.4. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн аймгийн спортын наадмыг 2 жил тутам зохион байгуулна.

- 
- 4.5. Бүсийн болон аймгийн аварга шалгаруулах "Сэлэнгэ лиг" спортын олон төрөлтийн тэмцээнийг жил бүр зохион байгуулж, жилд 5-аас доошгүй улсын болон бүсийн аварга шалгаруулах тэмцээнийг аймагтаа хүлээн авна.
 - 4.6. Төрийн албан хаагчдын дунд спортын олон төрөлтийн тэмцээнийг жил бүр зохион байгуулна.
 - 4.7. Аймгийн хэмжээнд үндэсний сур, шагайн харвааг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.
 - 4.8. Дугуйн болон явган аяллыг дэмжиж, хот суурин газрын авто замын дагуу явган хүний болон дугуйн зам байгуулна.
 - 4.9. Тамирчдыг олон улс, тив, дэлхийн уралдаан тэмцээнд оролцоход зохих дэмжлэг үзүүлдэг тогтолцоог бий болгоно.
 - 4.10. Биеийн тамир, спортын салбарын ажилтнуудыг орон сууцаар хангах ажлыг хэрэгжүүлж, урт хугацааны хөнгөлөлттэй зээлээр эзэмшүүлж, өмчлүүлснээр тогтвор суурьшилтай ажиллах, амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ.
 - 4.11. Ерөнхий боловсролын сургуулиудыг мэргэжлийн биеийн тамирын багшаар бүрэн хангаж биеийн тамир, спортын салбарын ажилтнуудыг үе шаттайгаар гадаад, дотоодод туршлага судлуулж, давтан сургаж, мэдлэг чадвар, мэргэжлийн ёс зүй, харилцаа, хандлага, хариуцлагыг дээшлүүлнэ.
 - 4.12. Биеийн тамир, спортын байгууллагуудын барилгын засвар, тохижилт, тоног төхөөрөмж, хэрэглэгдэхүүнээр хангах, шинэчлэх ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлж, иргэд ая тухтай орчинд биеийн тамир, спортоор хичээллэх боломжийг дээшлүүлнэ.

ТАВДУГААР БҮЛЭГ. АМЬДРАЛЫН ТААТАЙ ОРЧИН

Сэтгэл тайван иргэн – Аз жаргалтай амьдрал

- 5.1. Нийтийн ашиг сонирхлыг хамгаалах, иргэдийн эрүүл, аюулгүй орчинд ажиллах, амьдрах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор сумын төв сууринд, холбогдох хууль тогтоомж, дүрэм журам, норм, стандартыг мөрдүүлнэ.
- 5.2. Эрүүл мэндийн болон орчны тандалт нөлөөллийн үнэлгээ хийж агаар, хөрс, усны бохирдлыг багасгах арга хэмжээ авснаар эрүүл, аюулгүй орчныг бүрдүүлнэ.
- 5.3. Ногоон байгууламжийн талбайн хэмжээг нэмэгдүүлэх, цэцэрлэгжүүлэх, хамгаалахад иргэдийн оролцоог дээшлүүлнэ.
- 5.4. Интернэтийн хурдыг нэмэгдүүлснээр иргэдийн интернэтийн хэрэглээ сайжирна.
- 5.5. Зарим сумдад үерийн хамгаалалтын далан, хур тунадасны ус зайлуулах суваг, хоолойг байгуулна.
- 5.6. Хот, сум, суурин газрын "Хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах" чиглэлээр нэгдсэн судалгаа явуулж, шаардлагатай газруудад замын өргөтгөл, хатуу хучилттай замыг үе шаттайгаар барьж, хүчитгэл, нөхөлт хийж, стандартын шаардлага хангасан замын тэмдэг тэмдэглэгээг нэмэгдүүлнэ.
- 5.7. Баялгийн сан, Нийгмийн даатгалын сангаар дамжуулан төр, хувийн хэвшлийн түншлэлээр иргэдийг орон сууцжуулах ажлыг эхлүүлнэ.
- 5.8. Хөдөөгийн сэргэлтийн хүрээнд эхний гурван жилд 3 хувийн зээлийн хүүтэй, ипотекийн зээлийн 6 хувийн хүүтэй хөтөлбөрийн хүртээмжийг нэмэгдүүлнэ.

- 5.9. “Миний түрээсийн орон сууц” хөтөлбөрийн хүрээнд аймаг, сумдын иргэд түрээслэх, түрээслээд өмчлөх орон сууцны төслийн хүртээмжийг нэмэгдүүлнэ.
- 5.10. Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгах ажиллагааг хэвшүүлж, дахин боловсруулах, байгаль орчинд хор, нөлөөгүй үйлдвэрийг байгуулах иргэдийн санаачилгыг дэмжинэ.
- 5.11. “Монгол улс дахь хуванцар хог хаягдлын дахин боловсруулалтын тогтвортой байдлыг хангах” төслийг хэрэгжүүлж, зарим сумдад “Хог хаягдал зохицуулах төв”-ийг байгуулна.
- 5.12. Сумдад хог хаягдлын төвлөрсөн цэгийн стандартын ландфиллын байгууламж, аюултай хог хаягдлыг түр хадгалах, устгах зориулалтын байгууламжийг үе шаттайгаар байгуулна.
- 5.13. Олон нийтийг хамарсан халдварт өвчин, цар тахал, байгалийн гамшиг зэрэг аюулыг эрсдэлгүй даван туулахад бэлдэж, нэгдсэн стратеги бүхий бэлэн байдлын цогц эрсдэлийн менежментийн төлөвлөгөөг боловсруулж, жил бүр тодотгож хэрэгжүүлнэ.
- 5.14. Гамшигт үзэгдлүүд (ган зуд, газар хөдлөлт, хүчтэй шороон шуурга, үер, гал түймэр г.м)-ийн тархалт, давтамж, нийгэм, эдийн засагт үзүүлэх нөлөөлөл, эрсдэл аюулын талаар судалгааг тогтмол явуулж, эрсдэлээс урьдчилан сэргийлэх бодлого хэрэгжүүлнэ.
- 5.15. Цагдаагийн байгууллага бүрд стандартын шаардлага хангасан эрүүлжүүлэх байр, өрөөг үе шаттайгаар барьж ашиглалтад оруулснаар иргэний эрх зөрчигдөхөөс сэргийлнэ.


Иргэдийнхээ хөгжих, таатай амьдрах, ажиллах, тав тухтай амрах цэвэр, ногоон орчныг бүрдүүлсэн, эрүүл чийрэг, бүтээгч, оюунлаг иргэдтэй аймаг болно.

ЗУРГААДУГААР БҮЛЭГ. ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ

Хөдөлмөрч иргэн – Элбэг хангалуун амьдрал

- 6.1. Томоохон аж ахуйн нэгж, үйлдвэрийн нийгмийн хариуцлагын хүрээнд жижиг, дунд үйлдвэрийг дэмжих санал, санаачилгыг урамшуулж, дэмжих замаар кластерын хөгжлийг хангана.
- 6.2. Бичил, жижиг, дунд бизнес эрхлэгчдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, гарааны бизнес эрхлэх арга, ур чадварыг хөгжүүлж, өрсөлдөх хэмжээнд чадварыг дээшлүүлж ажлын байр, өрхийн орлогыг нэмэгдүүлнэ.
- 6.3. Өрхийн аж ахуйн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний борлуулалтыг дэмжих, бэлтгэн нийлүүлэлтийн сүлжээ бий болгох ажлыг эхлүүлнэ.
- 6.4. Орон нутгийн иргэдийн бие даасан, бүтээлч үйлдвэрлэлийг дэмжиж “Нэг суурин-Нэг бүтээгдэхүүн” хөтөлбөрийг аймгийн хэмжээнд хэрэгжүүлнэ.
- 6.5. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн, хүнд үйлдвэр, барилгын салбарын анхан, дунд, эцсийн шатны бүтээгдэхүүн үйлдвэрлэх төслүүдийг хэрэгжүүлнэ.
- 6.6. Зорилтот бүлгийн өрхүүдэд амьжиргааг дэмжих төслийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.
- 6.7. Бизнес эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, сунгах үйл ажиллагааг бүрэн цахимжуулж, технологийн дэвшлийг ашиглаж хүний оролцоо, төрийн хүнд суртлыг арилгана.

- 6.8. Ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлд жижиг, дунд, бичил бизнесийг дэмжих урт хугацаатай, хүү багатай зээлийн хүртээмжийг нэмэгдүүлж, шударга, ил тод олгох зарчмыг баримтлан хэрэгжүүлнэ.
- 6.9. Иргэдэд нийтийн эзэмшлийн зам талбай, цэцэрлэгт хүрээлэн зэрэгт үйлчилгээ эрхлэх боломжийг олгоно.
- 6.10. Жижиг, дунд үйлдвэрийн бүтээгдэхүүний борлуулалтыг төрийн худалдан авалтаар дэмжинэ.
- 6.11. Жижиг, дунд бизнес эрхлэгчдийг бизнес инкубацийн үйлчилгээгээр бойжуулан хөгжүүлэх бодлого баримтална.



ДОЛООДУГААР БҮЛЭГ. НИЙГМИЙН ХАМГААЛАЛ

- 7.1. Хүүхэд хамгааллын талаар мэдлэг, ойлголт, хандлагыг нэмэгдүүлэх нөлөөллийн ажлыг хэрэгжүүлж, иргэдийн оролцоотой хүүхдийг эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлнэ.
- 7.2. Хувь хүн, гэр бүлтэй ажиллах нийгмийн ажилтан, сэтгэл зүйчдийн ажиллах орчныг сайжруулна.
- 7.3. Гэр бүлийн хүчирхийллийг бууруулж, хүчирхийллийг үл тэвчих хандлагыг бий болгох нөлөөллийн арга хэмжээг хэрэгжүүлнэ.
- 7.4. Ахмадуудын эрүүл мэнд, нийгмийн хамгааллын үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэн геронтологич эмч ажиллуулж идэвхтэй насжилтыг дэмжинэ.
- 7.5. Ахмад настны тухай хуулийг бүрэн хэрэгжүүлэгч аймаг болно.
- 7.6. Ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, орлогыг нэмэгдүүлэх, мэдлэг туршлагаа залуучуудад өвлүүлж үлдээх боломжийг бүрдүүлнэ.
- 7.7. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан дэд бүтцийн стандартыг бүх төрлийн орон сууц, худалдаа үйлчилгээний байгууллагуудад мөрдүүлнэ.
- 7.8. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн өдөр өнжүүлэх төвийг байгуулж нийгэмшүүлэх, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, тэдний асран хамгаалагчдын хөдөлмөр эрхлэх боломжийг нэмэгдүүлнэ.
- 7.9. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийн талаарх зөв ойлголт, хандлагыг нийгэмд төлөвшүүлэх бодлогыг хэрэгжүүлнэ.

НАЙМДУГААР БҮЛЭГ. ЭДИЙН ЗАСГИЙН ТОГТВОРТОЙ ӨСӨЛТ

8.1. Хариуцлагатай уул, уурхай, хилийн боомтын хөгжил, найдвартай цахилгаан, дулааны хангамж

- 8.1.1. Аймгийн нутаг дэвсгэрт уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдийн лиценз эзэмшилтийг иргэдэд нээлттэй болгож, хууль зөрчиж олгосон зөвшөөрлийг хүчингүй болгуулна.
- 8.1.2. Уул уурхайн нөхөн сэргээх ажлын хяналтыг сайжруулж, нөхөн сэргээлт хийгээгүй аж ахуйн нэгжид ногдуулах хариуцлагыг чангатгана.
- 8.1.3. Хариуцлагатай уул уурхайг дэмжин хамтран ажиллаж, уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа компаниудаас нийгмийн хариуцлагын хүрээнд хөрөнгө төвлөрүүлж “Сэлэнгийн баялаг” санг байгуулан, байгалийн баялгийн үр шимийг аймаг, сумдын хөгжилд зарцуулна.

- 8.1.4. Зэлтэр хилийн боомтыг байнгын ажиллагаатай болгох ажлыг эхлүүлнэ.
- 8.1.5. Төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээгээр 50 МВт-ын Сүхбаатар дулааны цахилгаан станцыг барьж ашиглалтад оруулна.
- 8.1.6. Мандал суманд 25 МВт-ын дулааны цахилгаан станц барих ажлыг төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээгээр эхлүүлнэ.



8.2. Аялал жуулчлал

Аялал жуулчлалын салбарыг аймгийн эдийн засгийн тогтвортой хөгжлийн салбар болгон хөгжүүлнэ.

- 8.2.1. Аялал, жуулчлалын агентлаг, аяллын операторын чиглэлээр нэн шаардлагатай хүний нөөц, мэргэжилтэн бэлтгэнэ.
- 8.2.2. Аймгийн аялал жуулчлалын маршрут, зар сурталчилгааг сайжруулж хөгжүүлнэ.
- 8.2.3. Аймгийн соёл, орон нутгийн онцлогт тохирсон брэнд бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрөл, чанар, дизайныг сайжруулан, хөгжүүлж, нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлалыг хөгжүүлнэ.
- 8.2.4. Монголын их түүх, шашин, соёлын хадгалагдаж үлдсэн өв, тусгай хамгаалалттай газар нутгийн нөөц, даацад тулгуурласан эко аялал жуулчлал болон томоохон голуудын сав дагуух спорт аялал жуулчлалыг хөгжүүлнэ.
- 8.2.5. Жуулчдад зориулсан аймгийн онцлог бүхий урлаг соёлын хөтөлбөр, эвент арга хэмжээнүүдийг бий болгож тогтмолжуулна.
- 8.2.6. Аялал жуулчлалын бүс дэх хоршоо, нөхөрлөлийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн, үйлчилгээг ногоон зээл, худалдааны сувгуудаар дэмжих бодлого баримтлана.
- 8.2.7. Аялал, амралт, жуулчлалын чиглэлд дэд бүтцийг сайжруулж, дөрвөн улирлын аяллыг хөгжүүлнэ.
- 8.2.8. Аялал жуулчлалаар зорин очих газруудад ариун цэврийн байгууламж бүхий түр буудаллах цэг, үйлчилгээний цогцолбор байгуулна.

8.3. Газар тариалан

Үржил шим бүхий хөрсөнд тариалсан монгол таримлын өрсөлдөх чадвар, үнэ цэнийг өсгөж, экспортыг нэмэгдүүлсэн, ухаалаг технологид суурилсан газар тариаланг хөгжүүлнэ.

- 8.3.1. Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнийг жилийн дөрвөн улиралд бэлтгэн нийлүүлэх, хадгалах хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг дэмжинэ.
- 8.3.2. Стратегийн хүнсний зориулалттай болон жимс жимсгэнэ, мөөг зэрэг шинэ нэр төрлийн таримлын тариалалт, үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, хүлэмжийн аж ахуйг хөгжүүлнэ.
- 8.3.3. Тариалангийн үйлдвэрлэлд тэг болон цомхотгосон, усалгааны хэмнэлттэй дэвшилтэт технологи нэвтрүүлж, байгальд ээлтэй бордооны хэрэглээг төлөвшүүлж, хөрсний үржил шимийг хамгаалж, сайжруулна.
- 8.3.4. Дөрвөн улирлын хүлэмж, агуулах, зоорийн аж ахуйг хөгжүүлэх замаар хүнсний ногоо, жимс жимсгэнийн нэр төрлийг нэмэгдүүлж, дотоодын хэрэгцээнд жилийн турш тогтвортой нийлүүлж, шинэ ургацын ногооны хангамжийг сайжруулна.

- 8.3.5. Газар тариалангийн нийт эргэлтийн талбайн ашиглалтыг сайжруулж, зөвхөн атаршсан газрыг эргэлтэд оруулж, усалгаатай талбайн хэмжээг нэмэгдүүлнэ.
- 8.3.6. Аймгийн газар тариалангийн эргэлтийн талбайн 40 хувиас доошгүйд уринш бэлтгэж, газар тариалангийн тогтвортой хөгжлийг хангана.
- 8.3.7. Тариалангийн хөрсний үржил, шимийг нэмэгдүүлэх, хөрс бордох, үр ашигтай технологийг нэвтрүүлэх, ургамал хамгааллын цогц арга хэмжээг хэрэгжүүлж, бордооны хангамжийг 70 хувьд хүргэнэ.
- 8.3.8. Газар тариалангийн салбарт ашиглаж байгаа эргэлтийн талбайн хөрсийг хамгаалах, үржил шимийг нэмэгдүүлэх талаар газар эзэмшигчийн хүлээх үүрэг, хариуцлагыг өндөржүүлнэ.

8.4. Мал аж ахуй

- 8.4.1. Аймгийн хэмжээнд бий болгосон малын үүлдэр, генийн санг хамгаалж, цөм сүргийг тогтвортой өсгөн малчин иргэдэд түгээн дэлгэрүүлж малын ашиг шимийг нэмэгдүүлнэ.
- 8.4.2. Мал, амьтны өвчний гаралт, тархалтыг бууруулж, аймгийн түвшинд халдварт өвчнөөр тайван байдлыг баталгаажуулна.
- 8.4.3. Мал эмнэлгийн үйлчилгээний мэргэжлийн, шуурхай, нэгдмэл байдлыг хангах, мал эмнэлгийн үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлнэ.
- 8.4.4. Байгаль экологи, бэлчээрийн даацтай уялдуулж, малын тоо, төрөл, бүтцийн дээд хязгаарыг тогтоох, бэлчээрийн мэргэч амьтад, шавжтай тэмцэх, малын бэлчээр, хадлан, тэжээл, усны хангамж, хүрэлцээг нэмэгдүүлж, мал аж ахуйн эрсдэлийг бууруулна.
- 8.4.5. Дэвшилтэт технологи, техник бүхий эрчимжсэн мал аж ахуй, гахай, тахиа шувуу, зөгийн аж ахуйг шат дараатайгаар хөгжүүлнэ.
- 8.4.6. Шинэ хоршоо-Чинээлэг малчин” хөтөлбөрийг хэрэгжүүлж, малчин өрхийн амьжиргааг дэмжин, мал, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний мөнгөн урсгалыг тогтмолжуулж, малчдын орлогыг нэмэгдүүлнэ
- 8.4.7. Хоршоололд суурилсан хамтын хариуцлагын 3-5 жилийн хугацаатай хөнгөлөлттэй зээл, хагас эрчимжсэн мал аж ахуйг дэмжих хөрөнгө оруулалтын хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
- 8.4.8. Малчид хоршоолох замаар мах, сүү, арьс шир боловсруулах цех байгуулах, сум дундын хоршооллыг бүсчлэн байгуулж, малчдад хувь эзэмшүүлэх ажлыг эхлүүлнэ.
- 8.4.9. Малчид, тариаланчдын залгамж халааг бэлтгэх аяныг хэрэгжүүлнэ.
- 8.4.10. Малын тэжээлийн үйлдвэрийг бүсчлэн байгуулах бодлого баримталж, өвс тэжээлийн нөөцийг нэмэгдүүлэх хүрээнд хувийн хэвшилтэй хамтран ажиллана.
- 8.4.11. Бэлчээрийг усжуулах, худагжуулах ажлыг үргэлжлүүлэн малын бэлчээрийг нэмэгдүүлнэ.
- 8.4.12. Цэцэрлэг, сургуулийн үдийн хоолонд сүү, сүүн бүтээгдэхүүний хэрэглээг нэмэгдүүлэх замаар малчдын орлогод дэмжлэг үзүүлнэ.
- 8.4.13. Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнийг дөрвөн улиралд бэлтгэн нийлүүлэх, хадгалах нэгдсэн тогтолцоог бүрдүүлэх ажлыг эхлүүлнэ.

ЕСДҮГЭЭР БҮЛЭГ. БАЙГАЛЬ ОРЧИН

- 9.1. Байгалийн унаган төрх, биологийн олон янз байдлыг хамгаалж, эко системийн тэнцвэрийг хадгалахад хувь нэмэр оруулсан иргэн, аж ахуйн нэгжийг урамшуулах тогтолцоог бүрдүүлнэ.
- 9.2. Ойн хөнөөлт шавжтай тэмцэх, ойн түймрээс урьдчилан сэргийлэх, хамгаалах менежментийг сайжруулах, ойн хомстол, доройтлыг бууруулахад чиглэсэн үйл ажиллагааг эрчимжүүлнэ.
- 9.3. Аймгийн нутаг дэвсгэрт үлийн цагаан оготны тархацын судалгааг явуулж бэлчээрт хөнөөл учруулж буй царцаа, үлийн цагаан оготно гэх мэт мэрэгч амьтадтай байгаль орчинд ээлтэй аргаар тэмцэн, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ.
- 9.4. Уул уурхай, газар тариалан, дэд бүтцийн байгууламж, хот байгуулалт, бэлчээр ашиглалтын улмаас эвдрэл, доройтолд орсон газрыг нөхөн сэргээж аж ахуйн зориулалтаар дахин ашиглах боломжтой болгон эргэлтэд оруулж, ашиглагчийн хариуцлагыг өндөржүүлнэ.
- 9.5. Хууль бус ан агнуур, модны хулгайг таслан зогсоож байгалийн үнэ цэн, өгөөжийг үнэлэн хамгаалж, анхдагч экосистемийн тэнцвэрт байдлыг хадгална.
- 9.6. Ой зохион байгуулалтыг тогтмол явуулж, ойн экосистемийн нөөц, төлөв байдал, ойн нөхөрлөлүүдийн үйл ажиллагааг жил бүр бодитоор үнэлж хариуцлагажуулна.
- 9.7. Хөрс хамгаалах, газрын доройтлыг бууруулах, цөлжилттэй тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангана.
- 9.8. Голын эх, ус намаг бүхий газруудыг орон нутгийн тусгай хамгаалалтад авч, барилгажих, эзэмших, бохирдуулахаас сэргийлэн шингээх чадварыг хэвээр нь хадгалах замаар үерийн эрсдэлийг бууруулна.
- 9.9. Байгаль орчны мэдээллийн нэгдсэн сан, байгалийн нөөц ашиглалтын бүртгэл, кадастрыг технологийн хөгжлийг ашиглан боловсронгуй болгож баяжуулах, байгаль орчны цахим зөвшөөрлийн системийг нэвтрүүлж мэдээллийн шуурхай байдал, хүртээмжийг нэмэгдүүлнэ.

АРАВДУГААР БҮЛЭГ. ШУДАРГА ЗАСАГЛАЛ, ГАДААД ХАРИЛЦАА

Иргэнд ойрхон төрийн үйлчилгээ

- 10.1. Төр, иргэний нийгэм, хувийн хэвшлийн санаачилга, оролцоо, хамтын ажиллагааг дэмжинэ.
- 10.2. Төрийн аливаа шийдвэр гаргалтад хүний эрхийн мэдрэмжтэй хандаж, хүний эрхийг зөрчсөн шийдвэрийг цуцалж, төрийн хүнд суртлыг арилгана.
- 10.3. Төрийн нууцад хамаарахаас бусад бүх шийдвэр, тогтоол, гэрээ, хэлцэл, мэдээллийн санг хэвлэл, олон нийтэд нээлттэй, ил тод болгоно.
- 10.4. Төрийн үйл ажиллагаа, төсвийн зарцуулалт, төрийн өмчит аж ахуйн нэгжүүдэд тавих иргэний болон хөндлөнгийн хяналтыг нэмэгдүүлж мэдээллийг ил тод, шилэн байлгана.
- 10.5. Бүх нийтээр дагаж мөрдүүлэх хэм хэмжээний шийдвэрийг гаргахаас өмнө иргэд, иргэний нийгмийн байгууллагаар үнэлүүлдэг тогтолцоог бүрдүүлнэ.

- 10.6. Эрх мэдлийн хуваарилалт, хяналт, тэнцлийг оновчтой болгож, орон нутгийн засаглалын тогтвортой, шударга, бүтээлч байдлыг хангана.
- 10.7. Төрийн албан хаагчийн цалин хөлс, шагнал, урамшуулал олгох, албан тушаал дэвшүүлэх, бууруулах, халах, чөлөөлөхөд тухайн албан хаагчийн ажлын гүйцэтгэл, үр дүнгээс хамаарах тогтолцоог төлөвшүүлнэ.
- 10.8. Төрийн албан хаагчийн ёс зүй, хандлагыг ажлын гүйцэтгэлийн үнэлгээний чухал хэсэг болгон хэвшүүлж, үйлчилгээний соёлыг дээшлүүлнэ.
- 10.9. Төрийн байгууллагын үйл ажиллагаа, үйлчилгээний талаар иргэд санал бодлоо цахим хэлбэрээр чөлөөтэй илэрхийлэх нөхцөлийг хангаж, цахим хэлэлцүүлгийн технологийг хөгжүүлнэ.
- 10.10. Хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөрөөр хэрэгжиж байгаа ажил, арга хэмжээнд дотоод аудитыг чанартай гүйцэтгэж үр дүнг олон нийтэд тогтмол мэдээлнэ.
- 10.11. Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, авлигатай тэмцэх үйл ажиллагааг эрчимжүүлнэ.
- 10.12. Төрийн албан хаагчийн тасралтгүй сурч хөгжих тогтолцоог бүрдүүлж, хүний нөөцийн чадавхыг бэхжүүлж, нийгмийн баталгааны зохистой бодлогыг баримтална.
- 10.13. Төрийн албанд таваас дээш жил үр бүтээлтэй ажиллаж, сүүлийн гурван жилд нь “маш сайн” үнэлэгдсэн төрийн албан хаагчийг гадаадад хэлний бэлтгэл болон ахисан түвшний сургалтад хамруулна.
- 10.14. ОХУ, БНХАУ болон хамтын ажиллагаатай бусад улс, хот, мужуудтай тогтоосон харилцаагаа бэхжүүлж, хамтран ажиллах эдийн засгийн чиглэлийг нарийвчлан тодорхойлж, хөрөнгө оруулалт, экспорт, дэвшилтэт техник, технологийг дэмжсэн бодлого хэрэгжүүлнэ.
- 10.15. Төрийн алба, аялал жуулчлал, боловсрол, эрүүл мэнд, мэдээлэл, соёлын харилцааг дэмжсэн гадаад бодлогыг хэрэгжүүлнэ.

АРВАН НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. ОРОН НУТГИЙН ЧАНАРТАЙ ХОТЫН ШИНЭЧЛЭЛ

- 11.1. Гэр хорооллын боломжтой хэсгийг инженерийн дэд бүтэцтэй болгох, дахин төлөвлөлтийг хийж, иргэдийг орон сууцжуулах, төсөл, хөтөлбөрийг үе шаттай хэрэгжүүлнэ.
- 11.2. Нийтийн орон сууцны хуучин барилгын гадна фасадыг шинэчлэн засварлах, дулаан алдагдлыг бууруулах ажлыг хувийн хэвшил, иргэдийн оролцоотойгоор хэрэгжүүлнэ.
- 11.3. Орон сууцны төлөвлөлтөд оршин суугчид амрах, чөлөөт цагаа өнгөрүүлэх, нийгмийн дэд бүтэц, ногоон байгууламж, хүүхдийн тоглоомын талбай, биеийн тамирын талбай бүхий орчин бүрдүүлэх стандартыг хэрэгжүүлнэ.
- 11.4. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох зорилгоор хяналтын камерын нэгдсэн төв бий болгож үйл ажиллагааг тогтмолжуулна.
- 11.5. Төвлөрөл, суурьшсан нутаг дэвсгэрийн тэлэлт, газар зохион байгуулалт, авто замын сүлжээ, нийтийн тээвэр гэх мэт шаардлагатай төлөвлөлтийг тооцон хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулж, хот байгуулалтын үйл ажиллагааг үргэлжлүүлнэ.

- 11.6. Хаягдал бохир ус цэвэрлэх байгууламжийг өргөтгөж стандартын шаардлага хангасан ариун цэврийн байгууламжаар хангана.
- 11.7. Ус хангамжийн эх үүсвэрийн барилга байгууламжийг шинэчлэх, өргөтгөх замаар ард иргэдийг шаардлага хангасан ундны усаар хангана.
- 11.8. Иргэдэд байнгын халуун, хүйтэн усны найдвартай хангамжийг бий болгоно.
- 11.9. Хотын доторх авто замыг хүчитгэн шинэчилж, зарим цэгт өргөтгөн, төмөр замтай огтлолцсон хэсэгт зөөлөн орц, гарцыг хийнэ.
- 11.10. Хот тохижилт, нийтийн аж ахуйн тоног төхөөрөмжүүдийг шинэчилж, хүчин чадал, төрлийг нэмэгдүүлснээр үйлчилгээний хурд, чанарыг дээшлүүлнэ.
- 11.11. Гудамж талбайн гэрэлтүүлгийг нэмэгдүүлж бүрэн камержуулан, ард иргэдийн аюулгүй байдлыг хангаж, гудамж, талбайн нэр, байшин барилгын хаягийн стандарт хангуулж, хотын соёлыг нэмэгдүүлнэ.
- 11.12. Хүн амын суурьшлын бүсэд үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгж байгууллагуудын халаалтын нам даралтын зуухыг бүрэн зогсоож, халаалтын төвлөрсөн системд холбуулснаар агаарын бохирдлыг бууруулж, иргэдийн эрүүл амьдрах орчныг дээшлүүлнэ.
- 11.13. Шаардлагатай тохиолдолд хотын эдийн засаг, тохижилт, нийгмийн өмнө тулгарч байгаа бэрхшээлүүд, түүнийг шийдвэрлэх арга замын талаар асуулга боловсруулан ард иргэдээр эрэмбэлүүлэх, сонголт хийлгэх замаар иргэдийн оролцоог хангана.
- 11.14. Сайжруулсан түлшний үйлдвэр байгуулж айл өрхийн нүүрсний хэрэглээг багасгаснаар хотын агаарын бохирдлыг бууруулна.
- 11.15. Худалдаа, үйлчилгээ, аялал жуулчлалд зориулагдсан гудамжийг байгуулна.
- 11.16. Нийтийн тээврийн тогтмол үйлчилгээг бий болгоно.
- 11.17. Гэр бүлийн хүчирхийлэлд өртөж байгаа хүүхэд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг хамгаалах төрөлжсөн түр хамгаалах байр, гэр бүлийн хүчирхийллийн хохирогчдод мэдээлэл, зөвлөгөө өгөх төвийг байгуулна.
- 11.18. Хотын барилга байгууламжийг паспортжуулах, тэдгээрийн чанар, насжилтыг тодорхойлох, газар хөдлөлтийн үед тэсвэрлэх чадварт хянан баталгаажуулалт хийх, эрсдэлтэй байгууламжийг хүчитгэх, эсвэл буулгаж шинэчлэн барилгажуулах ажлыг зохион байгуулж иргэдийн амар тайван орчныг бэхжүүлнэ.
- 11.19. Хүүхдийн парк бүхий соёл амралтын цэцэрлэгт хүрээлэн байгуулна.

Иргэдийнхээ хөгжих, тав тухтай, сэтгэл дүүрэн амьдрах, ажиллах, амрах орчныг бүрдүүлсэн хөдөлмөрийн үнэлэмж өндөртэй, эрүүл чийрэг, бүтээгч, оюунлаг иргэдтэй, амар тайван хот болно.

Сэлэнгэ аймгийн МАН-ын Хорооноос 2024 оны Сэлэнгэ аймгийн ИТХ-ын сонгуульд оролцохдоо дэвшүүлж байгаа аймаг, орон нутгаа хөгжүүлэх энэхүү зорилтуудыг Та бид хамтран хэрэгжүүлж, ахмад үеийнхээ хөдөлмөрч, дайчин, шударга уламжлалыг хадгалж, хойч үеийнхээ ирээдүйн сайн сайхны төлөө Сэлэнгэ сайхан нутгаа "ХАМТДАА ХӨГЖҮҮЛЬЕ".